



Захиргааны хэм хэлжээний  
актын улсын нэгдсэн санд  
2019 оны 26. сарын 17-ны  
өдрийн 14.00 дугаарт бүртгэв.

ХЭНТИЙ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
АРВАННЭГДҮГЭЭР ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 03

Чингис хот

Журам, тариф батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арваннэгдүгээр Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах булшлах журмыг 1 дүгээр хавсралтаар, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардлын нэгж тарифыг 2 дугаар хавсралтаар, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, тосгоны Захирагч наарт, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Ганбямба/-д үүрэг болгосугай.



**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН  
АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ**

Аймийн цогцэний Төлөөлөгчдийн  
Хурлын №105 дугаар сарын 17.-ны  
өдрийн 11. дүгээр хуралдааны 12. дугаар  
тогтоотын 11. дүгээр хөвсрэлт

**Нэг. Нийтлэг үндэслэл.**

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуй нэгж байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, байнга болон түр оршин суугч иргэн, малчин өрх харьяалалгүй хүн дагаж мөрднө.

1.3. Журмыг сумдын Засаг дарга, тосгодын Захирагчийн ажлын алба шууд хариуцан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.4. Журмаар зохицуулагдаагүй харилцааг "Хог хаягдлын тухай" хуулийг удирдлага болгон зохицуулна. Хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд журамд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулна.

**Хоёр. Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах.**

2.1. Хог хаягдал гаргагч бүр үүсгэсэн хог хаягдлаа ангилан зориулалтын саванд хийх.

2.2. Өөрийн эзэмшил, өмчлөлийн газартай зориулалтын ангилан ялгах хогийн сав байрлуулах.

2.3. Аж ахуйн нэгж, байгууллага бүр энгийн хог хаягдлыг ангилан ялгаж, савлах тээвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

**Гурав. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулах**

**3.1. Хоёрдогч түүхий эдийг цуглуулах, худалдан авах:**

3.1.1. Хоёрдогч түүхий эдийг цуглуулах ажлыг сумдын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсан этгээд хүлээн авна. Гэрээнд цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх, орчны тохижилт, ариун цэврийн талаарх тодорхой зааж өгнө.

3.1.2. Хоёрдогч түүхий эдийг худалдан авахдаа цэг байгуулах замаар болон явуулын машинаар үйлчилгээг зохион байгуулна.

3.1.3. Хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгийг орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахуйц газар байгуулж үл болно.

3.1.4. Гэр хороололд хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгийг гудамжны эхэнд болон төгсгөлд гал, усны аюулгүй газарт, айл өрх, хашаанаас зайдуу байршилд байгуулна. Харин орон сууцны хороололд хоёрдогч түүхий эд цуглуулах явуулын машин үйлчилгээг нийтэд хүртээмжтэй байхаар зохион байгуулах.

3.1.5. Хоёрдогч түүхий эд худалдаж авах цэг нь өөр зүйл худалдах, худалдан авах эрх эдлэхгүй.

3.1.6. Хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газрын эрх бүхий байцаагч, тухай сумын ЗДТГ, багийн Засаг дарга хяналт тавина.

3.1.7. Мэргэжлийн хяналтын газраас тухайн хоёрдогч түүхий эд худалдан авах цэгийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоон.

3.1.8. Хог хаягдлыг цуглуулах худалдан аваад шаардагдах бүх зардлыг энэ үйлчилгээг явуулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хариуцна.

3.1.9. Цуглуулсан хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээг тухайн иргэн, аж ахуйн нэгж сумдын Засаг даргын тамгын газарт, хагас бүтэн жилээр гаргаж өгнө.

### 3.2. Хоёрдогч түүхий эдийн дахин боловсруулах:

3.2.1. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах иргэн, аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нелөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэсэн байна.

3.2.2. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулахдаа байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлж ажилана.

3.2.3. Ажилчдадаа хог хаягдлын талаар сургалт хийх, мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл авах.

3.2.4. Мэргэжлийн хяналтын байгууллагаас тухайн хоёрдогч түүхий эд дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоон.

3.2.5. Дахин боловсруулан хоёрдогч түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг тухайн иргэн, аж ахуйн нэгж сумдын Засаг даргын тамгын газарт хагас, бүтэн жилээр гаргаж өгнө.

### 3.3. Бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх:

3.3.1. Сумдын Засаг дарга /Тосгодын захирагч/ нар хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.

3.3.2. Гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, байгууллага хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг холбогдох стандартад нийцүүлэн явуулах.

3.3.3. Айл өрхийн хог хаягдлыг баталсан графикийн дагуу тогтмол хугацаанд тээвэрлэнэ.

3.3.4. Аж ахуйн нэгж, байгууллагын хогийг гэрээний дагуу тогтсон хугацаанд мөн дуудлагаар ачиж цуглуулан, хогийн төвлөрсөн цэгт хүргэнэ. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхдээ хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авна.

### 3.4. Хог хаягдлыг устгах, булшах:

3.4.1. Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргж, холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу булаж, устгана.

**Дөрөв. Оролцогч талуудын хүлээх үүрэг.**

### 4.1. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

4.1.1. Хууль, журмыг хэрэгжүүлэхэд нь сумдын ЗДТГ болон иргэн, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажилана.

4.1.2. Хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд нь сумгад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.3. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох.

### 4.2. Сумын Засаг даргын хүлээх үүрэг.

4.2.1. Нутаг дэвсгэрийнхээ албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх өдөр, хуваарийг батлах.

4.2.2. Ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулан, сонгон шалгарсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллах.

4.2.3. Нутаг дэвсгэрийнхээ айл өрх, байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд хог хаягдлыг ангилан ялгаж хаях талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу урамшуулах.

4.2.4. Нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг ангилан ялгаж хаях, цуглуулах, устгах үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг сумын төсөвт тусгаж санхүүжүүлэх.

4.2.5. Нийтийн эзэмшилийн гудамж зам талбайд хог хаягдлыг ангилан хаях, хадгалах, тэдгээрийг цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бурдүүлэх.

**4.3. Тосгоны захирагч, Багийн Засаг даргын хүлээх үүрэг:**

4.3.1. Сумын Засаг даргын баталсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн дагуу графикийг гаргаж мөрдүүлнэ. Нутаг дэвсгэрийн айл, өрх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг энэхүү журамд заасны дагуу ангилан ялгуулах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих.

4.3.2. Багийн оршин суугчид болон байгууллага аж ахуйн нэгж, сууц өмчлөгчдийн холбоог хамруулан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

4.3.3. Ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын хог тээвэрлэлтийн график, хугацаа, давтамжид хяналт тавьж хамтран ажиллах.

4.3.4. Хоёрдогч түүхий эд худалдан авч буй цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих.

**4.4. Айл өрх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг:**

4.4.1. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.

4.4.2. Хог хаягдлыг цуглуулахдаа орон сууцны хороолол, гэр хороолол, байгууллага аж ахуйн нэгж гэж 3 төрлөөр ангилна. Үүнд:

Орон сууцны хороолол:

Орон сууцны айл өрх дахин ашиглах боломжтой хог хаягдаа хоёрдогч түүхий эдийг цуглуулагч, иргэн аж ахуйн нэгж, харин бусад энгийн хог хаягдалыг байр, орцны нэгдсэн хогийн цэг, нэгдсэн хогийн цэггүй тохиолдолд тогтсон хугацаанд шууд хог тээврийн машинд, ахуйн аюултай, эмнэлгийн хаягдлыг тусгай зориулалтын сав, хүлээн авах тусгай цэгт батлагдсан өдөр, хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

Гэр хороолол:

Дахин ашиглах боломжтой хог хаягдал бусад хог хаягдал гэсэн төрлөөр зориулалтын саванд хадгалах бөгөөд ( ахуйн аюултай, эмнэлгийн хаягдлыг тусгай зориулалтын хадгалах бөгөөд аюултай, эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг тусгай зориулалтын цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагад хүлээлгэн өгнө.

Байгууллага, аж ахуйн нэгж:

Дахин ашиглах боломжтой болон бусад хог хаягдлыг зориулалтын саванд хадгалах бөгөөд аюултай, эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг тусгай зориулалтын

машин техникт зааврын дагуу хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагад батлагдсан өдөр, хуваарийн дагуу хүлээлгэж өгнө.

**4.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг:**

4.5.1. Сумын Засаг даргын баталсан өдөр, хуваарийн дагуу дахин ашиглах болон бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрхлэх. Үйл ажиллагаандаа холбогдох чиглэлээр гарсан хууль дүрэм, журам, Монгол Улсын стандартыг мөрдеж ажиллах.

4.5.2. Иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүйгээр, хурээлэн буй орчныг бохирдуулахгүйгээр, замын хөдөлгөөний дүрмийн сахиж хөдөлгөөнд оролцож хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэх.

4.5.3. Тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ бусад мэдээллийг улирал бүр сумын Засаг дарга Тамгын газар, Хот тосгоны Захирагчийн ажлын албанад гаргаж өгнө.

**Тав. Хүлээх хариуцлага**

5.1. Хог хаягдлын тухай хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Зургаа. Урамшуулал**

6.1. Хог хаягдлын анхан шатанд ангилан ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачлага гаргасан, мөн хоёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулахад бусад үлгэр дуурайлал болсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, олон нийтэд сурталчлах, бүх талаар дэмжих ажиллана.

6.2. Дээрх дэмжлэг, урамшууллын арга хэмжээг тухайн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.

---оОо---

Аймгийн цргээдийн Төлөвлөгчдийн  
Хурлын 10 дугаар сарын 17-ны  
өдрийн 11 дугаар хуралдааны 13 дугаар  
тогтоолын 12 дугаар хөвсргээтийн

НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ  
ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /га/	Үнийн тариф /төг/
1	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф	1	6000-9000



2315108216 № 9076298

Аймгийн иргэдийн Төлөвлөгчдийн  
Хурлын Муфын Ахугаар Сарын Ажлыны  
өдрийн И. дүзээр хурааданыг дуваар  
тогтоолын 03 дугаар хавсралт

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАРЖ БУЛАХ  
ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ



№	Сумдын нэр	Хэмжих нэгж /тн/	Үнийн тариф /тог/
1	Хэрлэн, Бор-Өндөр	1	10000-15000
2	Бусад сумд	1	8000-12000

